

“ЭРДЭНЭС СИЛВЕР РЕСУРС” ХХК-ИЙН САЛХИТЫН УУРХАЙН ХААЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛАХ ЖИШИГ ТӨСЛИЙН МЭДЭЭ

Дугаар 13 2022 оны 11-р сар


■ ГАЗАР ХЭЛБЭРШҮҮЛЭЛТИЙН ЗУРАГ ТӨСЛИЙН АЖЛЫН ЯВЦ

Төлөвлөлтийн баг 11-р сард газар хэлбэршүүлэлтийн зураг төсөл боловсруулахад төвлөрөн ажиллаж, гурван удаагийн уулзалт, хэлэлцүүлэг хийлээ. Багийн уулзалтуудаас гарсан санал зөвлөмжүүдийг үндэслэн шинэчлэн сайжруулсан хувилбаруудыг тухай бүрд нь дахин танилцуулж, хэлэлцүүлж байв. Ийнхүү багийн хэлэлцүүлгийн дүнд хаягдал чулуулгийн овоолго 1 ба 2, ил уурхайн үүсмэл нуур, хаягдлын сан, баяжуулах үйлдвэр зэрэг уурхайн үндсэн байгууламжуудыг хэлбэршүүлэх инженерийн зураг төслийг урьдчилсан байдлаар боловсруулав.

Газар хэлбэршүүлэлтийн зураг төслийг “Эвдрэлд өртсөн талбайг байгалийн унаган төрхөд ойртуулж, нутгийн иргэдийн уламжлалт газар ашиглалтыг дэмжихүйцээр нөхөн сэргээх” хэмээх Салхитын уурхайн хаалтын үндсэн зорилгод нийцүүлэн боловсруулж, нутгийн иргэдийн саналыг авахаар ажиллаж байна.

Газар хэлбэршүүлэлтийн зураг төслийг дараах таван зарчмыг баримтлан боловсруулж байна. Үүнд:

- Геотехникийн тогтворжилтыг хангасан байх
- Нөхөн сэргээсэн талбай нь хүн ам, хүрээлэн буй орчинд физик аюул, эрсдэл учруулахгүй байх
- Нөхөн сэргээсэн талбай нь хүн ам, хүрээлэн буй орчинд химийн бохирдол, эрсдэл учруулахгүй байх
- Гадаргын болон газрын доорх усны чанарын хувьд холбогдох хууль тогтоомж, стандартын шаардлагуудад нийцсэн байх
- Санхүүгийн хувьд үр ашигтай, хэрэгжихүйц байх



Зураг 1. Ил уурхайн газар хэлбэршүүлэлтийн изометр проекц



Зураг 2. Газар хэлбэршүүлэлтийн багийн ажил №6. 2022.11.15

ДАРААГИЙН ШАТАНД ХИЙГДЭХ АЖЛУУД

Боловсруулсан газар хэлбэршүүлэлтийн зураг төслийг “Эрдэнэс Силвер Ресурс” ХХК- хянаж, компанийн зүгээс баталгаажуулсны дараа төслийн оролцогч талууд, нутгийн иргэдэд танилцуулж, саналыг нь авах болно. Төлөвлөлтийн багаас уг зураг төслийг боловсруулахад иргэдийн өмнө өгч байсан саналуудыг хэрхэн тусгасан тухай эргэж тайлагнахаас гадна уурхайн хаалтын зорилго, зорилтуудыг хэрэгжүүлэхэд газар хэлбэршүүлэлтийн ажил яагаад чухал болохыг тайлбарлах юм. Оролцогч талууд, нутгийн иргэдийн санал зөвлөмжид үндэслэн зураг төсөлд бага зэргийн өөрчлөлтүүд хийж болзошгүй.

Дараагийн шатанд газар хэлбэршүүлэлтийн баг уурхайн байгууламж тус бүрийн инженерийн нарийвчилсан зураг төслийг боловсруулж, хаалтын өртөг зардал тооцоолол болон нөхөн сэргээлтийн ажилд шаардагдах суурь мэдээллийг бэлэн болгоно.

■ ТӨСЛИЙН ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН 11-Р САРЫН УУЛЗАЛТ

Төслийн хэрэгжилт, цаашид хийгдэх ажлуудын талаар оролцогч талуудыг мэдээллээр хангах, тэднээс чиглэл зөвлөмж авах, дэмжлэгийг хүлээх зорилго бүхий оролцогч талуудын уулзалтыг тогтмол зохион байгуулдаг билээ. Жишиг төслийн 2-р үе шатанд талуудын хамтын ажиллагаа, ялангуяа нөлөөлөлд өртөж буй нутгийн иргэдийн оролцоог хангахад онцгой анхаарал хандуулж байна. Төсөл хэрэгжилтийн явцад тулгамдаж буй хүндрэл бэрхшээл, эрсдэл ба боломжуудыг хууль тогтоох байгууллагууд болон орон нутгийн иргэд зэрэг оролцогч талуудад тухай бүрд нь мэдээлж байх нь чухал юм.



Зураг 3. 2022 оны 11 сарын 22-нд болсон төслийн оролцогч талуудын ээлжит уулзалал

суралцаж, “Эрдэнэс Монгол” ХХК-ийн нийт 20 охин компанид төслийн сайн туршлагыг нэвтрүүлэхийг эрмэлзэж байна. Удирдах зөвлөл хаалтын зардлыг компанийн бизнес төлөвлөгөөнд үе шаттай тусгаж, тогтвортой байдлыг хангаж ажиллана” гэв.

■ ЧАДАВХ БЭХЖҮҮЛЭХ СУРГАЛТ

11-р сард уурхайн хаалтын төлөвлөгөөг боловсруулахад олон улсын сайн туршлагуудыг танилцуулах, төлөвлөлтийн багийн гишүүд хаалтын менежментийн тэргүүлэх арга барилаас суралцах боломжийг олгох сүүлчийн Чадавхжуулах сургалтуудыг зохион байгуулав.

11-р сарын 1 ба 8-ны өдрүүдэд “Хаалтын дараах хяналт-шинжилгээ, мониторинг” чадавх бэхжүүлэх сургалт зохион байгуулав. Сургалтаар уурхайн хаалтын дараах хяналт-шинжилгээний ажлын зорилго, олборлолтын үеийн орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрөөс ялгагдах онцлог талууд, хяналт-шинжилгээний ажлын хүрээ болон шалгуур үзүүлэлт, хэмжих арга хэрэгслийн талаар мэдлэг олгов. Түүнчлэн хаалтын хяналт-шинжилгээний хөтөлбөрийн бүтэц, загварыг гаргахад шалгуур үзүүлэлт тодорхойлох хуудсыг хэрхэн ашиглах талаар танилцуулсан.

11-р сарын 15-ны өдөр “Дасан зохицох менежмент” чадавх бэхжүүлэх сургалтыг зохион байгуулж, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох менежментийн тухай үндсэн асуудлууд, Хаалтын төлөвлөгөөний зорилго, зорилтын биелүүлэхэд дасан зохицох менежментийг үе шаттай хэрэгжүүлэх ач холбогдлыг танилцуулав. Төлөвлөлтийн баг ургамалжуулалт болон усны хяналт-шинжилгээ чиглэлээр бүлгийн ажил хийх замаар дасан зохицох менежментийн үндсэн зарчмуудаас суралцлаа.

■ УУЛ УУРХАЙ, ЭРДЭС БАЯЛАГ, МЕТАЛЛ, ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН АСУУДЛААРХ ЗАСГИЙН ГАЗАР ХООРОНДЫН 18 ДАХЬ УДААГИЙН ЧУУЛГА УУЛЗАЛТЫН ҮЕЭР MERIT ТӨСӨЛ САЛХИТЫН УУРХАЙН ХААЛТЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛАХ ЖИШИГ ТӨСЛИЙГ ТАНИЛЦУУЛАВ.

11-р сарын эхээр Швейцар улсын Женев хотноо болсон Уул уурхай, эрдэс баялаг, металл, тогтвортой хөгжлийн асуудлаарх Засгийн газар хоорондын 18 дахь удаагийн чуулга уулзалтад MERIT төслийн Суурин төлөөлөгч Женнифер Адамс оролцож, танилцуулга хүргэв. Тэрбээр уурхайн хаалт болон хаалтын дараах шилжилтийн үе шатууд дахь нийгэм-эдийн засаг, иргэдийн асуудал хэлэлцсэн салбар хуралдааны үеэр “Монгол улсын Засгийн Газартай хамтран хэрэгжүүлж буй Жишиг төслийн хүрээнд уурхайн хаалтын чиглэлээр чадавх бэхжүүлэх нь” сэдэвт илтгэл танилцуулав.

Илтгэл дараах үндсэн агуулгыг хамрав.

- Жишиг төслийн хэрэгжилтэд Чадавх бэхжүүлэх зарчмыг хэрэгжүүлж, төслийн үйл ажиллагаа бүрд оролцогч талуудыг мэдээллээр хангах, мэдлэг туршлагыг бэхжүүлэх арга хэмжээг зохион байгуулж байна.
- Оролцогч талуудын оролцоо, хамтын ажиллагааг хангахад чиглэсэн бодлого, үйл ажиллагаа нь тухайн компанийн нөөц бололцоо, санхүүгийн чадамжид тохирсон бодитой, хэрэгжихүйц байх нь чухал.
- Оролцоо, хамтын ажиллагааг хангах үйл ажиллагааг сайн төлөвлөн хэрэгжүүлснээр иргэдийн идэвх оролцоог өндөр байлгах боломжтой. Иргэдийн саналыг сонсож, олон талаас нь хэлэлцэж хаалтын төлөвлөлтөд тусгах нь тэдний оролцоог идэвхжүүлэх томоохон хөшүүрэг болдог.

Чуулганы төлөөлөгчид Монгол улсад уурхайн хаалтын хууль эрхзүйн орчныг сайжруулах, оролцогч талуудын оролцоо, хамтын ажиллагааг хангах чиглэлээр MERIT төслөөс хэрэгжүүлж буй үйл ажиллагаа, туршлагыг ихээхэн сонирхож байв.

Тус арга хэмжээний талаарх хураангуй тайланг дараах холбоосоор орж үзнэ үү. <https://enb.iisd.org/igf-agm-2022-mining-minerals-metals-summary>



Зураг 4. Уул уурхай, эрдэс баялаг, металл, тогтвортой хөгжлийн асуудлаарх Засгийн газар хоорондын 18 дахь удаагийн чуулга уулзалтад MERIT төслийн Суурин төлөөлөгч Женнифер Адамс оролцоо.

Эх сурвалж: Тогтвортой хөгжлийн олон улсын хүрээлэн (IISD)

Бид та бүхэнд Салхитын уурхайн хаалтын мэдээ мэдээллийг аль болох сонирхолтой байдлаар хүргэхийг зорьдог билээ. Төслийн оролцогч талуудын санал, сэтгэгдлийг сонсож, бэлтгэж буй мэдээ мэдээллийг уншигчдын хэрэгцээ, сонирхолд нийцүүлэх нь чухал юм. Тиймээс та бүхэн төслийн сар тутмын мэдээтэй холбоотой санал сэтгэгдлээ бидэнтэй хуваалцана уу.

Дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл Төслийн захирал
Р.Алтангэрэлтэй имэйл хаягаар холбогдоно уу.
r.altangerel@merit.mn